


Үндэсний хөгжлийн газрын даргын 2017 оны 06 дугаар сарын 22 -ний өдрийн А.7.9 тоот тушаалын нэгдүгээр хавсралт



**Дэлхийн тогтвортой хөгжлийн зорилтууд болон
“Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-тэй
уялдсан Дунд хугацааны хөгжлийн төлөвлөгөө боловсруулахад
зөвлөх үйлчилгээний ажлын даалгавар**

Зөвлөх үйлчилгээний нэр: Монгол Улсад Тогтвортой хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэх бэлтгэл ажилд зөвлөх үйлчилгээ үзүүлэх нь
Гэрээний төрөл: Байгууллага
Хэрэгжүүлэгч байгууллага: Үндэсний хөгжлийн газар
Гэрээний хугацаа: 5 сар

1.ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Монгол Улс төвлөрсөн төлөвлөгөөт тогтолцоог 1990 онд халснаас хойш стратегийн, урт хугацааны төлөвлөлт хийхийг хэд хэдэн удаа оролдсон. Гэвч, эдгээр төлөвлөлтүүд нь бодит бус, санхүүжилттэй уялдаагүй байсны улмаас үр ашигтай байж чадаагүй. Түүнчлэн, дөрвөн жил тутам сонгуультай холбоотойгоор Засгийн газрын үйл ажиллагааны чиглэл өөрчлөгддөг байдал, ойр ойрхон хийгддэг засгийн газрын шинэчлэл болон төлөвлөлтийн бичиг баримт олширсон зэрэг томоохон асуудлууд тулгарч байв. Сонгууль бүрийн дараа шинэ засгийн газрын боловсруулдаг Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр нь нийт улсын болон орон нутгийн хэмжээнд хэрэгждэг дунд хугацааны хөгжлийн бодлогын суурь баримт бичиг байсаар ирсэн.

17 тогтвортой хөгжлийн зорилтууд бүхий 2030 он хүртэлх дэлхийн Тогтвортой Хөгжлийн Хөтөлбөр (ДТХХ) батлагдсан нь Монгол Улс хөгжлийн төлөвлөлтийн тогтолцоондоо шинэчлэл хийх эхлэл цэг болж өгсөн. Тус хөтөлбөр батлагдсаны дараа 2015 оны 11 сард Монгол Улсын Их Хурал үрт, дүнд, богино хугацааны үндэсний болон орон нутгийн хөгжлийн бодлогын уялдааг хангах эрх зүйн үндэс болох Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийг баталсан. Түүний дараагаа 2018 оны 2 сард Монгол Улсын Их Хурлаас урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг болох Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030 (МУТХҮБ-2030)-ыг баталсан бөгөөд энэхүү үзэл баримтлалыг боловсруулахдаа ДТХХ-ийг гол чиглэлээ болгосон.

2016 оны 7 дугаар сард Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт орсноор Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээнд үндэсний хөгжлийн цогц бодлого байхаар хуульчилсан. Үүний дагуу УИХ-ын 2016 оны 12 дугаар тогтоол, Ерөнхий сайдын 164 дүгээр захирамжаар Үндэсний хөгжлийн газар (ҮХГ)-ыг 2016 оны 9 сард байгуулсан.

Үндэсний хөгжлийн газар нь өөрийн бүрэн эрхийн хүрээнд ДТХХ-ийн дагуу, салбарын хөгжлийн уялдааг ханган нийтлэг асуудлуудыг шийдвэрлэх МУТХҮБ-2030-ыг хэрэгжүүлэх эхний үе шатны төлөвлөгөө буюу Дунд хугацааны хөгжлийн төлөвлөгөөг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулсан. Энэхүү ажлын даалгаварт оролцогч талуудын хэлэлцүүлгийг үндэсний болон орон нутгийн түвшинд хийх бөгөөд үүнээс гарсан үр дүнг ДТХХ болон МУТХҮБ-д суурилсан хөгжлийн бодлогын төлөвлөлтийн удирдамжид тусгах юм.

2. АЖЛЫН ЗОРИЛГО

- Бодлогын уялдаа, тэргүүлэх чиглэлийг ДТХЗ болон МУТХҮБ-2030-тэй нийцүүлэн, улсын хөрөнгө оруулалт, төсвийн хүрээтэй уялдуулан тодорхойлох Дунд хугацааны хөгжлийн төлөвлөгөөг боловсруулахад ҮХГ-т техникийн туслалцаа үзүүлэх,
- Хөгжлийн урт хугацааны бодлогын зорилтуудтай өнөөгийн байгаа бодлогын баримт бичгүүдийн нийцтэй байгаа эсэхэд үнэлгээ хийх ажилд удирдамж болгох, бодлогын үнэлгээ хийх, хүрэх үр дүнг тодорхойлох аргачлал, арга зүйг боловсруулах;
- Бодлогын баримт бичигт үнэлгээ хийх үйл явцыг уялдаа холбоотой, тал бүрийн оролцоотой гүйцэтгэхэд ҮХГ-т зөвлөх, дэмжлэг үзүүлэх.

3. ХИЙХ АЖЛЫН ХҮРЭЭ

ДТХЗ болон МУТХҮБ-2030-д нийцсэн эхний үе шатны төлөвлөгөө боловсруулахад дараах ажлын хүрээнд ҮХГ-т дэмжлэг үзүүлэх чиглэлээр дараах ажлыг гүйцэтгэнэ:

1. Үндэсний болон салбарын хэмжээнд хүчинтэй хэрэгжиж буй бодлого, төлөвлөлтийн баримт бичгүүд, холбогдох судалгаа, илтгэл тайлан, зарлиг, тушаал, удирдамж, журам, дүрэм журам зэрэг төлөвлөлтийн баримт бичгүүд болон ТХЗ, МУТХҮБ 2030-ийн суурь түвшингүүдийг судлан шинжлэх. Түүнчлэн, өнгөрсөн хугацаан дахь улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн хэрэгжилтийг салбарын бодлогын тэргүүлэх чиглэлтэй харьцуулан судлан шинжлэх;
2. Үндэсний болон салбарын хөгжлийн бодлогын ДТХЗ, МУТХҮБ 2030-тай уялдаатай байдалд үнэлгээ хийх болон салбарын бодлогыг үнэлэхэд зориулан салбар хоорондын ажлын хэсгүүдтэй хамтран тэргүүлэх үйл ажиллагааны чиглэл, дараалал (хүрэх түвшинг)-ыг тодорхойлох зорилготой олон улсын жишигт нийцсэн аргачлал, арга зүйг боловсруулах;
3. Дээр дурдсан аргачлалыг хэрэглэн, баримт бичгүүдийг үнэлсэн нотолгоонд суурилсан дүн шинжилгээ мөн тодорхой шалгуурт тулгуурлан үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл, дараалал, хүрэх түвшинг тодорхойлох;
4. Салбар, салбар хоорондын оролцогч талуудын оролцоотой хэлэлцүүлгийн үр дүнд үндэслэн ДТХЗ, МУТХҮБ 2030-ын 2021, 2025, 2030 онуудад хүрэх түвшинг тодорхойлох (жил бүрийн хүрэх түвшинд тухайн жил тутам тодотгол хийгдэнэ);
5. ДТХЗ, МУТХҮБ 2030, дунд хугацааны санхүүжилт, зардлын хүрээ болон бусад санхүүжилтийн эх үүсвэрт нийцсэн Дунд хугацааны хөгжлийн төлөвлөгөөний төслийг боловсруулах (одоогоор хийгдэж буй Хөгжлийн санхүүжилтын үнэлгээний үр дүн, дүгнэлтийг тусгах боломжтой);

6. Ажлын даалгаварын 1 дүгээр заалт дахь бодлогын баримт бичгийг нягтлан судлах үйл явцаас гарсан үр дүнд болон Дунд хугацааны хөгжлийн төлөвлөгөөг боловсруулахад олж авсан мэдлэгт үндэслэн Дунд хугацааны хөгжлийн төлөвлөгөө болон салбарын, орон нутгийн төлөвлөлт, төсөвлөлт, Засгийн Газрын үйл ажиллагааны төлөвлөгөө хоорондын уялдаа холбоо, нийцлийг хангах аргачлалын төслийг бэлтгэх;

Үндэсний статистикийн газар, Сангийн яам, орон нутгийн засаг захиргаа, НҮБ-ын агентлаг, бусад ДТХЗ, МУТХҮБ 2030-ийг хэрэгжүүлж буй оролцогч талуудтай хамтарч ажиллана.

4. ХҮЛЭЭГДЭЖ БУЙ ҮР ДҮН

Зөвлөх үйлчилгээнээс гарах гол үр дүн нь төсөв болон хяналт шинжилгээ, үнэлгээний механизмтай уялдаа бүхий Дунд хугацааны хөгжлийн төлөвлөгөө (МУТХҮБ 2030-ын эхний 5 жилийн төлөвлөгөө) байх юм.

Зөвлөх үйлчилгээнээс гарах бүтээгдэхүүнийг дараах хуваарийн дагуу хүлээлгэн өгөх болно.

Хүрэх үр дүн	Хугацаа
1. Бодлогын баримт бичгүүдийн өнөөгийн байдлыг судлан шинжилсэн тайлан	Гэрээ байгуулснаас хойш 15 хоног
2. Бодлогын баримт бичгүүдийн хоорондын уялдаа болон ДТХЗ, МУТХҮБ 2030-тай нийцсэн байдалд үнэлгээ хийх, бодлогын хүрэх түвшинг тодорхойлох аргачлал, арга зүй	Гэрээ байгуулснаас хойш 60 хоног
3. Үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл, дараалал болон 2021, 2030 оны ДТХЗ, МУТХҮБ 2030-ийн хүрэх түвшин	Гэрээ байгуулснаас хойш 90 хоног
4. Санхүүгийн эх үүсвэртэй уялдсан, хяналт шинжилгээ, үнэлгээний механизмтай Дунд хугацааны хөгжлийн төлөвлөгөө	Гэрээ байгуулснаас хойш 120 хоног
5. ТХЗ, МУТХҮБ 2030-ийг хэрэгжүүлэх хүрээнд нэгдсэн төлөвлөлт, төсөвлөлт, тайлагнах үйл явцыг төлөвлөх аргачлал	Гэрээ байгуулснаас хойш 150 хоног

*Захиалагчтай байгуулсан гэрээнд зааснаар үр дүнг хүлээлгэн өгөх хугацааг тооцно.

5. БАГИЙН БҮТЭЦ, БҮРЭЛДЭХҮҮН

Уг зөвлөх үйлчилгээг хамгийн багадаа 4 зөвлөхтэй хуулийн этгээд (төрийн бус байгууллага, зөвлөх үйлчилгээний компани эсвэл эрдэм шинжилгээний байгууллага) 5 сарын хугацаанд гүйцэтгэж.

6. ЗӨВЛӨХ БАГТ ТАВИГДАХ ШААРДЛАГА

А. Зөвлөх үйлчилгээ үзүүлэх байгууллага нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. Хөгжлийн бодлого, төрийн захиргааны чиглэлээр зөвлөх үйлчилгээ үзүүлж байсан 7-с доошгүй жилийн туршлагатай,
2. Төрөл бүрийн салбаруудын тоон мэдээлэл болон бодлогод дүн шинжилгээ хийж байсан туршлагатай, багийн гишүүдээс дор хаяж нэг зөвлөх нийгмийн салбараас бусад салбарын мэргэжил боловсролтой байх,
3. Энэхүү ажлын даалгаварт заагдсан чиглэлээр аналитик судалгаа хийж, хөгжлийн баримт бичиг боловсруулж байсан туршлагатай,
4. Үр дүнд суурилсан хөгжлийн төлөвлөгөө, хөтөлбөр боловсруулж байсан туршлагатай,
5. Уулзалт, хэлэлцүүлэг, хурал, зөвөлгөөн, семинар зохион байгуулж байсан туршлагатай,
6. НҮБ болон/эсвэл бусад олон улсын байгууллагатай хамтран ажиллаж байсан туршлага нь давуу тал болно.

Б. Зөвлөхүүд нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. Багийн ахлагч/Төрийн бодлогын зөвлөх

- (i) Төрийн бодлого, Төрийн захиргаа, Хөгжлийн бодлого ба төлөвлөлт, Эдийн засаг, Улс төр, Нийгмийн шинжлэх ухаан зэргийн аль нэгээр магистр болон түүнээс дээш зэрэгтэй,
- (ii) Төрийн, Төрийн бус болон /эсвэл Төрийн бодлогын чиглэлийн байгууллагад 8 болон түүнээс дээш жил ажилласан туршлагатай (олон улсын орчинд ажилласан бол давуу тал болно),
- (iii) Салбарын болон салбар хоорондын бодлогын судалгаа, бодлогын шинжилгээ, бодлого боловсруулалт, төсөвлөлт болон/эсвэл төслийн удирдлага чиглэлээр ажиллаж байсан туршлагатай,
- (iv) Монгол Улсын Тогтвортой Хөгжлийн Үзэл Баримтлал – 2030 болон Дэлхийн Тогтвортой Хөгжлийн Зорилтуудын талаар ойлголттой байх,
- (v) Төрийн болон олон улсын байгууллагуудтай ажиллаж байсан туршлагатай
- (vi) Англи, Монгол хэлний бичгийн болон ярианы өндөр мэдлэгтэй.

2. Төрийн захиргаа/Төрийн бодлогын зөвлөх

- (i) Хөгжлийн бодлого ба төлөвлөлт, Төрийн бодлого, Эдийн засаг болон/эсвэл Хөгжлийн судалгааны чиглэлээр магистр болон түүнээс дээш зэрэгтэй,
- (ii) Салбарын бодлогын шинжилгээ, боловсруулалтын чиглэлээр 8 болон түүнээс дээш ажилласан туршлагатай (дэд бүтэц, хөдөө аж ахуй, аж үйлдвэр г.м. нийгмээс бусад салбарт ажилласан бол давуу тал болно),
- (iii) Хяналт-шинжилгээ, үнэлгээ, тайлангийн цогц систем боловсруулах ажлын туршлагатай,
- (iv) Монгол Улсын Тогтвортой Хөгжлийн Үзэл Баримтлал – 2030 болон Дэлхийн Тогтвортой Хөгжлийн Зорилтуудын талаар ойлголттой байх,
- (v) Төрийн болон олон улсын байгууллагуудтай ажиллаж байсан туршлагатай,
- (vi) Англи, Монгол хэлний бичгийн болон ярианы өндөр мэдлэгтэй.

3. Төрийн санхүүгийн чиглэлээр мэргэшсэн зөвлөх

- (i) Санхүү, статистик, эдийн засаг, математикийн чиглэлээр магистр болон түүнээс дээш зэрэгтэй,
- (ii) Төсөв, санхүүгийн чиглэлээр 8 болон түүнээс дээш ажилласан туршлагатай,
- (iii) Статистик шинжилгээний програм хангамж ашиглаж байсан туршлагатай,
- (iv) Судалгааны ажлын болон тайлан бичиглэлийн ажлын туршлагатай,
- (v) Монгол Улсын Тогтвортой Хөгжлийн Үзэл Баримтлал – 2030 болон Дэлхийн Тогтвортой Хөгжлийн Зорилтуудын талаар ойлголттой байх,
- (vi) Төрийн болон олон улсын байгууллагуудтай ажиллаж байсан туршлагатай,
- (vii) Англи, Монгол хэлний бичгийн болон ярианы өндөр мэдлэгтэй.

4. Нийгмийн бодлогын зөвлөх

- (i) Хөгжлийн эдийн засаг, Хөгжлийн судалгаа, Төрийн бодлого, Нийгмийн шинжлэх ухааны чиглэлээр магистр болон түүнээс дээш зэрэгтэй,
- (ii) Нөлөөллийн үнэлгээ хийх, бодлого боловсруулах болон/эсвэл нийгмийн бодлогын судалгаа шинжилгээ хийх ажлын 6-с доошгүй жилийн туршлагатай,
- (iii) Монгол Улсын Тогтвортой Хөгжлийн Үзэл Баримтлал – 2030 болон Дэлхийн Тогтвортой Хөгжлийн Зорилтуудын талаар ойлголттой байх,
- (iv) Төрийн болон олон улсын байгууллагуудтай ажиллаж байсан туршлагатай,
- (v) Англи, Монгол хэлний бичгийн болон ярианы өндөр мэдлэгтэй.

7. ЗОХИОН БАЙГУУЛАЛТ БОЛОН ТАЙЛАГНАХ МЕХАНИЗМ

Зөвлөх үйлчилгээ үзүүлэх байгууллага нь ҮХГ-тай гэрээ байгуулах бөгөөд Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн даргад ажлын үр дүнг шууд тайлагнана. ҮХГ-ын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс нь зөвлөх үйлчилгээ явуулахад шаардлагатай удирдамж, дэмжлэгээр хангана. Дэмжлэг дараах зүйлсийг багтаах бөгөөд зөвхөн үүгээр хязгаарлагдахгүй:

- Салбарын яамд болон бусад оролцогч талуудтай холбоо тогтоож өгөх,
- Холбогдох бичиг баримтаар хангах,
- Оролцогч талуудын уулзалт, зөвлөгөөн хийхэд дэмжлэг үзүүлэх,
- Нэгдсэн хөгжлийн загвар боловсруулахад ерөнхий чиглэл өгөх,
- Ерөнхий удирдамж өгөх болон шаардлагатай захиргааны бусад дэмжлэг.

ҮХГ болон НҮБХХ харилцан тохиролцсоноор энэхүү ажлын даалгаварт нэмэлт, өөрчлөлт оруулж болно. НҮБХХ нь энэхүү зөвлөх үйлчилгээнээс гарсан үр дүнд зохиогчийн эрх эзэмшинэ.

Огноо	Төлбөрийн хэсэг	Төлбөрийн нөхцөл
Үр дүн 1;2	40%	ҮХГ болон НҮБХХ үр дүнг хүлээн авсны үндсэн дээр
Үр дүн 3:	20%	
Үр дүн 4;5	40%	